



## СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Судалгааны ажлын сэдэв: Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа**

Монголбанкнаас санаачлан санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институтийг бэхжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж 2015 оны 10-р сарын 07-ны өдрийн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, БСШУЯ-ны сайд, СЗХ-ны даргын хамтарсан А-142/282/Б/403/274 дугаар тушаалаар батлуулсан. Тус дунд хугацааны хөтөлбөр хэрэгжсэний дараах иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшинг үнэлэх болон иргэдийн эдийн засгийн суурь мэдлэгийн түвшнийг тогтоох судалгааны ажлыг гүйцэтгэх судалгааны баг, байгууллагыг холбогдох материалаа ирүүлэхийг урьж байна.

**Судалгааны ажлын хамрах хүрээ, бүрдүүлэх материал**

|                                  |  |
|----------------------------------|--|
| Судалгааны хамрах хүрээ          | Улаанбаатар хот, Орон нутаг  |
| Судалгааны баг                   | <ul style="list-style-type: none"><li>• Судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд, хүрээлэн</li><li>• Их, дээд сургуулийн багш нар</li><li>• Төрийн бус байгууллага</li></ul>  |
| Түүврийн хэмжээ                  | <ul style="list-style-type: none"><li>• 2000</li></ul>   |
| Давтамж                          | <ul style="list-style-type: none"><li>• 1 удаа</li></ul>   |
| Судалгааг гүйцэтгэх хугацаа      | <ul style="list-style-type: none"><li>• 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 06-ны өдөр</li></ul>  |
| Гүйцэтгэх ажил, хүлээгдэх үр дүн | <ul style="list-style-type: none"><li>• Иргэдийн санхүүгийн болон эдийн засгийн мэдлэгийн түвшнийг тогтооход чиглэсэн сургуулийн насны ахлах ангийн сурагчид, залуу үе (Оюутан), хөдөө орон нутгийн иргэдийг оролцуулсан түүвэр судалгаа авч, үр дүнг нэгтгэж үнэлгээ хийх, тайлан бэлтгэх</li></ul> |
| Бүрдүүлэх материал               | Мэдүүлгээ ирүүлж буй судалгааны баг, байгууллага нь дараах материалыг ирүүлнэ: <ul style="list-style-type: none"><li>• Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх төсвийн санал</li><li>• Судалгаа хийх аргачлалын товч танилцуулга</li></ul>   |

|  |  |
|--|--|
|  | <ul style="list-style-type: none"><li>• Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх ажлын дэлгэрэнгүй хуваарь</li><li>• Судалгаа, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг туршлагатай, судалгааны чиглэлээр томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байсан тухай танилцуулга</li><li>• Судалгаа, шинжилгээ хийх, тайлан дүгнэлт боловсруулах чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний танилцуулга /3 нүүрээс хэтрэхгүй/</li></ul> |
|--|--|

Судалгааны ажлын талаарх нэмэлт мэдээллийг 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 09:00-18:00 цагийн хооронд Монголбанкны 311240 болон 310081 дугаараас авч болно. Материалаа дор дурдсан хаягаар 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 17:00 цагийн дотор ирүүлнэ үү.

**Хаяг:**

Монголбанк, Олон нийтийн санхүүгийн боловсролын төв  
Бага тойруу 3, 15160  
Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг